

Санхүүгийн тогтвортой байдалтай холбогдолтой материал, оюутан судлаачдад

- Олон улсын төлбөр тооцооны банкны дэргэдэх Базелийн банкны хяналт шалгалтын хороо “International regulatory framework for banks (Basel III)” 2010
<http://www.bis.org/bcbs/basel3.htm>
2007-2009 оны санхүүгийн хямралтай холбоотойгоор олон улсын түвшинд банкны бодлого, зохицуулалтыг өөрчлөх шаардлага гарсан бөгөөд 2010 онд Базелийн стандартыг шинэчлэн баталж, 2014 оноос мөрдүүлж эхлэхээр ажиллаж байна.
- Олон улсын төлбөр тооцооны банкны дэргэдэх Базелийн банкны хяналт шалгалтын хороо “Basel II: Revised international capital framework” 2006
<http://www.bis.org/publ/bcbsca.htm>
Олон улсын банкны өөрийн хөрөнгийн стандарт. Үүнд банкны өөрийн хөрөнгө, эрсдэлийн тооцоолол, тэдгээрт тавигдах шаардлага зэргийг тусгасан.
- Олон улсын валютын сан “Financial Soundness Indicators: Compilation Guide” 2006
<http://www.imf.org/external/pubs/ft/fsi/guide/2006/index.htm>
Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд нь тухайн улс орны санхүүгийн салбарын дүр зургийг харуулах бөгөөд олон улс орон дагаж мөрддөг тул улс орнуудаар харьцуулалт хийхэд тохиромжтой.
- Paul Krugman "A Model of Balance-of-Payments Crises", 1979
<http://www.jstor.org/stable/1991793>
Төлбөрийн тэнцлийн хямралын "нэгдүгээр үе"-ийн загваруудын суурийг Нобелийн шагналт эдийн засагч Пол Кругманы 1979 оны энэхүү алдарт судалгаа тавьсан. Судалгаанд валютын ханшийн эсрэг гэнэтийн дайралт нь хүлээлтийн рациональ бус өөрчлөлт мэт харагдаж байгаа боловч энэ нь хөрөнгө оруулагчдын зүгээс рациональ үйлдэл байх боломжтойг харуулснаараа онцлог юм.
- Maurice Obstfeld "Rational and Self-fulfilling Balance-of-Payments Crises" 1986
<http://www.jstor.org/stable/1804128>
Төлбөрийн тэнцлийн хямралын "хоёр дахь үе"-ийн загваруудын суурийг тавьсан энэхүү судалгаанд төр валютын хатуу ханшийг үргэлжлүүлэн барих эсэх талаарх эргэлзээ нь олон тэнцвэрийн цэгийг бий болгодог бөгөөд энэ нь улмаар хөрөнгө оруулагчдад бусад хөрөнгө оруулагчид валютын ханшийн эсрэг дайралт хийнэ гэсэн хүлээлт үүсвэл энэ нь өөрөө өөрийгөө хөөрөгдөж, валютын ханшийн хямралд хүргэх боломжтой гэдгийг харуулсан. Нэгдүгээр үеийн хямралын загварууд жишээ нь 1992 оны Европын валютын ханшийн механизм (European exchange rate mechanism)-ийн хямралыг тайлбарлаж чадахгүй байсан бол хоёрдугаар үеийн загварууд энэхүү хямралыг тайлбарлаж байсан.
- Wikipedia “Currency crisis”
http://en.wikipedia.org/wiki/Currency_crisis
Төлбөрийн тэнцлийн хямралын "гурав дахь үе"-ийн загварууд нь банк, санхүүгийн салбар дахь дутагдлууд төлбөрийн тэнцлийн хямралтай хэрхэн холбогддог болон санхүүгийн хямралууд бодит эдийн засагт хэрхэн нөлөөлдөг

тухай тайлбарласан байдаг. Эдгээр загварууд жишээ нь 1997 оны Азийн хямралыг илүү сайн тайлбарладаг байна.

- Graciela L. Kaminsky, Carmen M. Reinhart "The Twin Crises: The Causes of Banking and Balance-Of-Payments Problems" 1999

<http://www.jstor.org/stable/117029>

Энэхүү судалгаа нь банкны хямрал болон төлбөрийн тэнцлийн хямралын түүхэн тохиолдлуудад үндэслэн тэдгээрийн хоорондын хамаарлыг судалсан. Энэхүү судалгаа нь банк, санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох Early warning indicators аргачлалын хөгжилд ихээхэн нөлөө үзүүлсэн.

- Douglas W. Diamond, Philip H. Dybvig "Bank runs, deposit insurance, and liquidity" 1983

<http://minneapolisfed.org/research/QR/QR2412.pdf>

Энэхүү банкны хямралын талаар сонгодог судалгаа нь банкны хөрвөх чадвар муутай актив болон хөрвөх чадвар сайтай пассивын багц нь хадгаламж эзэмшигчдийн дунд өөрөө өөрийгөө хөөрөгдөх сандралыг үүсгэж, улмаар банкнаас хадгаламж хурдацтай гадагшлах үзэгдэлд хүргэж болохыг харуулсан.

- Douglas W. Diamond "Banks and Liquidity Creation: A Simple Exposition of the Diamond-Dybvig Mode" 2007

http://www.rich.frb.org/publications/research/economic_quarterly/2007/spring/pdf/diamond.pdf

Энэхүү судалгаанд Diamond-Dybvig загварыг харьцангуй энгийн байдлаар тайлбарласан.

- Guillermo A. Calvo, Carmen M. Reinhart "Fear of Floating" 2000

<http://www.nber.org/papers/w7993>

Энэхүү эмпирик судалгаанд валютын хөвөгч ханштай гэж зарласан олон улс орон үнэндээ валютын ханшийг далдуур барьж байдгийг харуулсан.

- Guillermo A. Calvo "Capital Flows and Capital-Market Crises: The Simple Economics of Sudden Stops" 1998

<http://www.cema.edu.ar/publicaciones/download/volume1/calvo.pdf>

Энэхүү судалгаанд хөрөнгийн орох урсгал ихтэй байсан орнуудад энэхүү урсгал гэнэт багасах нь банк, санхүүгийн болон төлбөрийн тэнцлийн хямралд хүргэж болох тухай харуулсан.